# ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2025.12.30 Эрдэнэт хот

| д/д | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Гүйцэтгэлийн үзүүлэлт | Хүрэх үр дүн | Биелэлт |
|---|---|---|---|---|
| 1 | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу байгууллагын үйл ажиллагааг албан ёсны вэб сайтад мэдээлж иргэд олон нийтийг мэдээллээр хангах | Байгууллагын үйл ажиллагаа Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу ил тод байх | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль хэрэгжсэн байна. | Худалдан авах ажиллагааны газрын https://khaag.erdenet.mn/ сайтад байгууллагын үйл ажиллагааг ил тод мэдээлэхээс 2024 онд Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх нийт 355 төсөл арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан батлуулж төлөвлөгөө болон гэрээ байгуулсан 311 тендерийн урилга, тендерийн нээлт, үр дүн, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн мэдээлэл, шалгарсан болон шалгарч чадаагүй үндэслэл шалтгааны талаарх мэдээллийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-нд тухай бүр оруулан ил тод мэдээлж ажилласан. 2024 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, давхардсан тоогоор 425 зарлалыг Аймгийн ЗДТГ-ын **www.erdenet.mn,** Аймгийн ИТХ-ын itkh-orkhon.gov.mn , Орон нутгийн_ www.erdenetnews.mn, Худалдан авах ажиллагааны газрын https://khaag.erdenet.mn/ сайтуудад ил тод мэдээлэхээс гадна ХАА-ны анхны төлөвлөгөөг Хотын шуудан сонины 2023.12.28-ний өдрийн 197 дугаар болон Худалдан авах ажиллагааны газрын мэдээллийн самбарт төлөвлөгөө болон |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | тендерийн урилга, үр дүнг олон нийтэд зарлан мэдээлж ажилласан. Төлөвлөгөөнд тодотгол орсон тухай бүр мөн иргэд олон нийтэд нээлттэй ил тод мэдээлсэн. |
| 2 | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, байгууллагын төсөв, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хуулийн хугацаанд олон нийтэд мэдээлэх | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байх | Шилэн дансны хуулийг хэрэгжүүлсэн байна. | 2024 онд байгууллагын Шилэн дансанд байршуулах сар бүрийн болон улирлын санхүүгийн мэдээллийг үнэн зөв, иж бүрэн оруулж, шилэн дансны сайтад хуулийн хугацаанд илгээж, байгууллагын санхүүгийн мэдээллийг самбарт ил тод байршуулан ажилласан. Тайлант жилд санхүүгийн 171 мэдээлэл оруулахаас 171 мэдээллийг шилэн дансанд үнэн зөв оруулж, сайтад хугацаанд нь илгээсэн. Тайлант хугацаанд шилэн дансны мэдээллээр Санхүүгийн дотоод аудит, хяналт шалгалтаар 100% үнэлгээ авсан. |
| 3 | Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, сар бүрийн тендер, шалгаруулалтын үр дүн, тайлан, худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлтыг Шилэн дансны тухай хуулийн дагуу нээлттэй ил тод мэдээлэх | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байх | Шилэн дансны хуулийг хэрэгжүүлсэн байна. | Аймгийн худалдан авах ажиллагааны 2024 оны анхны төлөвлөгөөнд тусгагдсан 91.2 тэрбум төгрөгийн 219 төсөл арга хэмжээний төлөвлөгөөг Шилэн дансны тухай хуулийн дагуу www.shilendans.gov.mn–сайтад хуулийн хугацаанд буюу 2024.01.05-ний өдөр оруулж ил тод мэдээлж ажилласан Тендер шалгаруулалтын сар бүрийн үр дүнг www.shilendans.mn-нд хуулийн хугацаанд оруулсан. 2024 оны 1-р сард 20, 2-р сард 113, 3-р сард 56, 4-р сард 25, 5-р сард 16, 6-р сард 27, 7-р сард 33, 8-р сард 16, 9-р сард 34, 10-р сард 33, 11-р сард 35 тендерийн нийт 408 тендер шалгаруулалтын үр дүнг шилэн дансанд оруулсан байна. Аудитын дүгнэлтийг 1 болон 5-р сард тус тус 2 удаа хуулийн хугацаанд нь оруулсан байна.Жилийн эцсийн тайланг хуулийн хугацаанд буюу |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | 2025.01.10-ний өдөр сайтад оруулж мэдээлсэн байна. |
| 4 | Байгууллагын ирсэн өргөдөл, гомдлын бүртгэл, шийдвэрлэлтийн байдлыг хангаж ажиллах | Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг бүртгэж, хянан шийдвэрлэх | Өргөдөл гомдолыг хуулийн хугацаанд нь шийдвэрлэсэн байна. | Тайлант хугацаанд иргэд, аж ахуйн нэгжээс байгууллагын үйл ажиллагаа, албан хаагчдын харилцаа хандлагатай холбоотой асуудлаар ямар нэг гомдол, санал ирээгүй. 2024 онд 26 тендерт гомдол гарсан. Үүнээс 14 тендер нь захиалагчийн шийдвэр үндэслэлгүй гэж шийдвэрлэгдсэн байна. Гомдлын бүртгэлийг хөтөлж шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллалаа. |
| 5 | Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангаж тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүн, тайлан, тендерийн нээлт, тендерт шалгарсан, шалгараагүй үндэслэл, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг худалдан авах ажиллагааны цахим системд, төлөвлөгөө урилга, тайлан мэдээг иргэд олон нийтэд ил тод мэдээлэх | Худалдан авах ажиллагааны мэдээлэл нээлттэй ил тод байх | Хууль, тогтоожийн хүрээнд байгууллагын худалдан авах ажиллагаа ил тод мэдээлэгдсэн байна. | 2024 онд Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх нийт 355 төсөл арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан батлуулж төлөвлөгөө болон гэрээ байгуулсан 311 тендерийн урилга, тендерийн нээлт, үр дүн, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн мэдээлэл, шалгарсан болон шалгарч чадаагүй үндэслэл шалтгааны талаарх мэдээллийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-нд тухай бүр оруулан ил тод мэдээлж ажилласан. Мөн 2024 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, давхардсан тоогоор 425 зарлалыг Аймгийн ЗДТГ-ын **www.erdenet.mn,** Аймгийн ИТХ-ын itkh-orkhon.gov.mn , Орон нутгийн www.erdenetnews.mn, Худалдан авах ажиллагааны газрын https://khaag.erdenet.mn/ сайтуудад ил тод мэдээлэхээс гадна ХАА-ны анхны төлөвлөгөөг Хотын шуудан сонины 2023.12.28-ний өдрийн 197 дугаар болон Худалдан авах ажиллагааны газрын |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | мэдээллийн самбарт төлөвлөгөө болон тендерийн урилга, үр дүнг олон нийтэд зарлан мэдээлж ажилласан. Төлөвлөгөөнд тодотгол орсон тухай бүр мөн иргэд олон нийтэд нээлттэй ил тод мэдээлсэн. |
| 6 | Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл, тайлбарыг гаргуулж авч, АТГ-ын мэдүүлгийн системд бүртгэх | Авлигын эсрэг хууль тогтоомж хэрэгжсэн байна. | Авлигын эсрэг хууль тогтоомж хэрэгжсэн байна. | АТГ-ын www.meduuleg.iaac.mn сайтад үнэлгээний хорооны гишүүд болон худалдан авах ажиллагаа зохион байгуулсан 1744 хүний мэдэгдэл тайлбарыг үнэлгээний хорооны бүрэлдэхүүнээс авч АТГ-ын мэдүүлгийн системд шивж оруулсан. |
| 7 | Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарыг бүртгэх, хянах, хадгалах ажлыг хуулийн дагуу зохион байгуулах | Авлигын эсрэг хууль,журам хэрэгжсэн байна. | Хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд үнэн зөв мэдүүлж хэвшинэ. | 2024 онд хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах албан хаагчдын нэрсийн жагсаалтыг Аймгийн ЭБАТ-д хүргүүлсэн. Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарыг бүртгэх, хянах, хадгалах ажлыг хуулийн дагуу зохион байгуулж ажилласан. Гарсан зөрчил дутагдал байхгүй.Байгууллагын ТЗ-8 зэрэглэлийн 1 ахлах мэргэжилтэний 2023 оны хөрөнгө орлогын мэдүүлгийг 2024.02.15-ний дотор www.meduuleg.iaac.mn сайтаар хүлээн авч хуулийн баталгаажуулсан.Үнэлгээний хорооны гишүүд болон худалдан авах ажиллагаа зохион байгуулсан 1744 хүний ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл, тайлбарыг хүлээн авч АТГ-ын мэдүүлгийн www.meduuleg.iaac.mn системд бүртгэсэн. |
| 8 | Авлигын эсрэг үйл ажиллагааны мэдээ тайлан, биелэлтийг холбогдох хэлтэст хүргүүлэх | Авлигын эсрэг хууль,журам хэрэгжсэн байна. | Тайлан, мэдээг хугацаанд нь хүргүүлсэн байна. | Авлигын эсрэг үйл ажиллагааны тайлан, мэдээг цаг хугацаанд нь Аймгийн Засаг даргын тамгын газар, Хууль зүйн хэлтэс, Хяналт–шинжилгээ үнэлгээ, дотоод |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | аудитын хэлтэст хүргүүлж ажилласан. |
| 9 | Аж ахуй нэгж байгууллага, иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээг ил тод, хөнгөн шуурхай хүргэх ажлыг зохион байгуулах | Иргэд, ААНБ-уудад чирэгдэлгүй үйлчилсэн байна. | Байгууллагын үйл ажиллагаа ил тод төрийн үйлчилгээ иргэдэд ААНБ-уудда түргэн шуурхай хүргэгдсэн байна. | Тендерт оролцогч иргэн, ААНБ-уудад худалдан авах ажиллагааны мэдээ, мэдээллийг тогтмол өгч ажилласан. Тайлант хугацаанд иргэд, аж ахуйн нэгжээс байгууллагын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар гомдол, санал ирээгүй байна. |
| 10 | Байгууллагын ажилтнуудад Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх | Авлигын эсрэг хууль, журам хэрэгжсэн байна. | Аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлнэ. | 2024 онд байгууллагын албан хаагч нарт ЭБАТ-ны зүгээс дараах 2 сургалтыг зохион байгуулан ажилласан. Үүнд:<br>1. Ашиг сонирхлын зөрчөл үүссэн, үүсэж болзошгүй нөхцөлд мэдэгдэл тайлбарыг хэрхэн гаргах тухай<br>2. Төрийн албан хаагчидад тавигдах хориглолт, хязгаарлалт, ёс зүйн шаардлагын талаарх сургалт |

БИЕЛЭЛТ ХЯНАСАН:

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ДАРГА Л.ОЮУНГЭРЭЛ

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Д.ОЮУНБАЯР